



Батлав. Сургалт, цахим шилжилтийн газрын захирал..... Н.Эрдэнэхүү

УЛИРЛЫН ШАЛГАЛТ, ТӨГСӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

2023-05-01

ЗОРИЛГО:

ШУТИС-ийн 2022-2023 оны хичээлийн жилийн хаврын улирлын шалгалт, төгсөлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдлөг болгоно.

ХАМРАХ ХҮРЭЭ:

СЦШГ, СБХА, АТХА, Бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын алба, салбар/тэнхим, профессор, багш нар, оюутан.

ХУГАЦАА: 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 16-ны хооронд

НЭГ. ХИЧЭЭЛИЙН ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ

- 1.1. Нийт профессор багш нар өөрийн заасан хичээлээр оюутны суралцах үйл ажиллагааны явцыг үнэлсэн дүнг(70 оноо) гаргаж багшийн веб хуудсаар дамжуулан UNIMIS системийн баазад 05 дугаар сарын 15-ны 09.00 цагаас 05 дугаар сарын 21-ний 23.00 цагийн хооронд оруулсан байна.
- 1.2. Оюутны явцын 70 онооны үнэлгээг гаргахдаа 2022-2023 оны хичээлийн жилийн хаврын улирлын сургалтад хамрагдан хичээлийн агуулгаа бүрэн судалж, идэвхтэй суралцсан оюутанд явцын 30-70 хүртэлх оноо олгоно.
- 1.3. Хичээл сонгосон, сургалтын төлбөрөө бүрэн төлсөн боловч эрүүл мэндийн асуудалтай байсан зэрэг хүндэтгэх шалтгаанаар танхимын болон цахим хичээлд хангалттай түвшинд хамрагдаагүй оюутнуудын бие даан суралцсан нотлох баримтад үндэслэн суурь 30 оноо өгөх эсэхийг хичээл заасан багш шийдвэрлэнэ.
- 1.4. Тухайн хичээлийн задаргаанаас хамаарч лекц, семинар, лабораторид харгалзах оноог хичээл заасан багш бүр багшийн вебээр дамжуулан UMIMIS-д оруулна.
- 1.5. Явцын 70 онооны дун оруулах хугацаа дууссаны дараа буюу 05 дугаар сарын 22-ны 08:00 цагаас сургалтын албаны ажилтан UNIMIS-д явцын дүнг татах ба ингэснээр дүнгийн баталгаажуулалт хийгдсэн гэж үзнэ.
- 1.6. Хүндэтгэх шалтгаантай явцын үнэлгээг буруу оруулж засвар хийх шаардлага гарсан тохиолдолд хичээл заасан багш 05 дугаар сарын 22-оос 05 дугаар сарын 25-ны 11:00 цаг хүртэл хугацаанд СЧА-ны даргад хүсэлт гаргана. СЧА-ны дарга хүсэлтийг хянаж үзээд хичээл заасан багшийн нэр, код, хичээлийн код, багшийн веб нээх хугацаа зэрэг мэдээлэл бүхий материалыг СБХА-нд ирүүлж шийдвэрлүүлнэ.
- 1.7. Оюутан улирлын шалгалтаас өмнө хичээлийн явцын үнэлгээтэй заавал танилцаж 30 онооны шалгалтад орох эсэхээ тодруулсан байна.

ХОЁР. УЛИРЛЫН ШАЛГАЛТ

- 2.1. ШУТИС-ийн хаврын улирлын шалгалтыг СБХА-наас гаргасан ерөнхий хуваарь, бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанаас гаргасан нэмэлт хуваарийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 05 дугаар сарын 31-ний хооронд тест, билет, аман шалгалт, компьютер ашигласан цахим тест хэлбэрээр зохион байгуулна.
- 2.2. Хаврын улирлын шалгалтын үйл ажиллагаанд салбар, тэнхим, сургалтын алба, СБХА, АТХА хяналт тавьж, удирдлагаар ханган ажиллана.
- 2.3. Сургалтын албад улирлын шалгалтын хуваарийг сургалтын XV долоо хоногт багтаан гаргаж, баталгаажуулсан мэдээллийг UNIMIS-д шивж оруулан оюутны вебээр дамжуулан хүргэхээс гадна шалгалтын хуваарийг сургууль дээр байрлуулж оюутан, багш наарт мэдээлэл хүргэсэн байна.
- 2.4. 2022-2023 оны хаврын улиралд хичээл заасан багш нар ШУТИС-аас гаргасан “Шалгалтын материал боловсруулах удирдамж”-ийн дагуу 30 онооны шалгалтын материалыг Хичээлийн Суралцахуйн Үр дүн(CLOs)-тэй уялдаатайгаар Блумын таксаномийн дагуу шинэчлэн боловсруулж, шалгалт авах өдрөөс 2 хоногийн өмнө салбар, тэнхимиийн эрхлэгчээр хянуулан СЧА-ны даргаар батлуулсан байна.
- 2.5. Хаврын улиралд заагдсан хичээлүүдийн 30 онооны шалгалтыг тусад нь ассистант багш томилж зохион байгуулахгүй, хуваарыт тусгасан хэлбэрээр хичээл заасан багш өөрөө зохион байгуулна.
- 2.6. Математик, физик гэх мэт ШУТИС-ийн хэмжээнд заагдсан хичээлүүдийн 30 онооны нэгдсэн шалгалтыг тухайн сургуульд хуваарилагдан хичээл заасан багш нарын баг зохион байгуулна.
- 2.7. Нэгдсэн шалгалтын материалыг тухайн сургуульд хүргэх, хурааж авчрах, шалгалтын материалыг засах, дүнг нэгтгэх, үнэлгээг UNIMIS-д оруулах зэрэг бүх үйл ажиллагааг үйлчилж байгаа сургууль хариуцна.
- 2.8. Нэгдсэн шалгалт зохион байгуулах анги танхим, багш нарын хуваарийг СБХА-наас гаргаж салбар, нэгжүүдэд хүргүүлсэн байх ба анги танхимиын бэлэн байдлыг бүрэлдэхүүн сургууль хариуцна.
- 2.9. Шалгалтын үед баримтлах дэгийг хичээл заасан багш салбар тэнхимиийн эрхлэгчтэй зөвлөлдөн тогтоо ба шалгалтын материал дээр шалгалт авах өдөр, хувилбар, үргэлжлэх хугацаа, даалгавар бурийн оноо дээд, доод хязгаар, хичээлийн тэмдэглэл, гарын авлага, тооны машин ашиглаж болох эсэх гэх мэт мэдээллийг дэлгэрэнгүй оруулсан байна.
- 2.10. Улирлын шалгалтыг цахимаар зохион байгуулахдаа Тестийн төв, TEAMS, MOODLE зэрэг платформыг ашиглах боломжтой ба шалгалтын үр дүн, чанарыг дээшлүүлэхийн тулд оюутнуудыг сургууль дээр ирүүлж, компьютерын лабораториудад зохион байгуулах чиглэл баримтална.
- 2.11. Тестийн төвөөр авах цахим шалгалтын хуваарийг СБХА-наас гарган бүрэлдэхүүн сургуулиуд болон тестийн төвд урьдчилан хүргэж бэлэн байдлыг хангасан байна.
- 2.12. Цахимаар шалгалт авч байгаа багш нар шалгалтын материалын 1 хувилбарыг файл хэлбэрээр татан авч хэвлүүлэн, салбарын эрхлэгчээр хянуулан, СЧА-ны даргаар батлуулсан байна.
- 2.13. Улирлын шалгалтын цахим материал боловсруулахдаа сонгосон системийн тестийн санг ашиглан олон хувилбартай тест хэлбэрээр(бакалаврын түвшинд 60-90 минут, ахисан түвшинд 90-120 минут) боловсруулна. Ингэхдээ программаар холилт хийн, оюутан бүрд өөр өөр

хувилбар гаргах, зөв хариултыг тайлан/report/ байдлаар оюутанд харуулахгүй байх, серверт ачаалал өгөхгүй тулд олон асуулт нэг хуудсанд зэрэг гарахаар тус тус тохиргоо хийсэн байна.

- 2.14. Салбарын эрхлэгч өөрийн салбарын бүх багш нарын улирлын шалгалтын материалыг нэгтгэн хавтаслаж, нотлох баримт байдлаар тестийн сан үүсгэн хадгална.
- 2.15. Хичээл заасан багш улирлын шалгалтын 30 онооны дүнг хуваарьт өдрөөс хойш 36 цагийн дотор багшийн вебээр дамжуулан UNIMIS системд оруулсан байна. 30 онооны дүн оруулахдаа үнэлгээг Блумын таксаномийн дагуу 3 хэсэгт хувааж оруулна.

ГУРАВ. И, Е ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГАЛТ

- 3.1. Хаврын улиралд заагдсан хичээлээр И, Е үнэлгээний шалгалт өгөх оюутнуудын бүртгэлийг үндэслэн сургалтын алба захиалгын нэгтгэлийг гаргаж тухайн хичээлийг хариуцаж байгаа сургууль, салбар, тэнхимээс томилсон багшийн бүртгэлийг оюутан бүрд оруулж өгнө.
- 3.2. 2022-2023 оны хаврын улиралд төгсөх оюутан энэ улиралд заагдаагүй хичээлээр Е үнэлгээний шалгалт өгөх хүсэлт гаргасан тохиолдолд бүртгэлийг сургалтын алба хийж, салбар/тэнхимиин эрхлэгчийн томилсон багшаар шалгалтын материал бэлтгүүлэн шалгалтын хугацаанд зохион байгуулна.
- 3.3. И, Е үнэлгээтэй оюутны шалгалтыг 30 оноогоор дүгнэнэ.

ДӨРӨВ. ТӨГСӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 4.1. ШУТИС-ийн төгсөлтийн үйл ажиллагааг СЦШГ, СБХА, АТХА, СЧА, төгсөлтийн салбар комисс тус тус удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.
- 4.2. Хаврын улирлын төгсөлтийн үйл ажиллагааг зохион байгуулахдаа “ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 13, 14, 15, 16, 17-р бүлэг, заалтуудыг удирдлага болгоно.
- 4.3. Салбар, нэгжүүд бакалавр, магистрын түвшний урьдчилсан хамгаалалт, улсын шалгалтын урьдчилсан тестийн шалгалтыг V/22-28-ний өдрүүдэд зохион байгуулна.
- 4.4. Улсын шалгалт өгөх оюутнуудад шалгалтын асуултууд, асуудал шийдвэрлэх жишээ даалгавруудыг урьдчилан хүргэж, багш нар давтлага зөвлөгөө өгсөн байна.
- 4.5. Дипломын нарийн бичиг улсын шалгалтын урьдчилсан тестийн шалгалтын материалыг бэлтгэж, салбарын эрхлэгчээр хянуулж СЧА-ны даргаар батлуулсан байна.
- 4.6. Журмын дагуу удирдагч 50 оноо, урьдчилсан хамгаалалт 20 оноогоор, урьдчилсан шалгалт 60 оноогоор тус тус үнэлэгдэх ба урьдчилсан хамгаалалтын дараах нийлбэр оноо, шалгалтын дүнг дипломын нарийн бичиг UNIMIS-д хуваарьт өдөр оруулна.
- 4.7. Бакалавр, магистрын түвшний урьдчилсан хамгаалалтын дараа жинхэнэ хамгаалалтад орох болзол хангасан оюутнуудын диплом, төгсөлтийн ажилд холбогдох засваруудыг хийлгэн, хэвлэмэл байдлаар төгсөлтийн нарийн бичиг хүлээн авна.

- 4.8. Бакалавр, магистрын төгсөлтийн нарийн бичиг дипломын төсөл, төгсөлтийн ажлын материалыг шүүмжид өгч уншуулан дүгнүүлнэ.
- 4.9. Салбарууд бакалавр, магистрын түвшний жинхэнэ хамгаалалт, төгсөлтийн шалгалтыг 2023 оны 05 дугаар сарын 29-оос 06 дугаар сарын 7-ны өдрүүдэд хуваарийн дагуу танхимаар зохион байгуулна.
- 4.10. Бакалаврын диплом, магистрын төгсөлтийн ажил хамгаалуулах үйл ажиллагааг профессор багш нар, ажил олгогчдоос бүрдсэн 5-9 хүний бүрэлдэхүүнтэй комисс зохион байгуулах ба оюутны хамгаалалтын үр дүнг ± 30 хүртэл оноогоор үнэлнэ. Шүүмжлэгчийн өгсөн оноог жинхэнэ хамгаалалтын комиссын оноонд оруулж тооцно.
- 4.11. Улсын шалгалтын материалыг бүрэлдэхүүн сургуулийн захирлын гарын үзэг, тамгаар баталгаажуулах ба оюутныг 40 хүртэл оноогоор дүгнэнэ.
- 4.12. Салбар комиссын нарийн бичгийн дарга комиссын шийдвэрийн дагуу оюутан бүрээр шалгалт, хамгаалалтын үнэлгээг гаргаж UNIMIS-д оруулан тогтоол, шийдвэрийг хэвлэж, хуваарын өдөрт багтаан гарын үсэг зуруулж баталгаажуулна.
- 4.13. Салбар комиссын нарийн бичгийн дарга диплом хамгаалалт явагдаж дуссаны дараа төгсөлтийн тогтоол, шийдвэр, төгсөгч оюутны мэдээллийг хөтөлбөр хариуцсан сургалтын албаны ажилтандаа хүлээлгэн өгнө.
- 4.14. Төгсөгч оюутны дипломын мэдээллийг системээс өгөгдсөн загварын дагуу хөрвүүлэн ШУТИС-ийн архивын стандартаар хэвлэж гарын үсэг зуруулахад бэлтгэнэ.
- 4.15. Салбар комиссын нарийн бичгийн дарга төгсөгч оюутнаар мэдээллийг хянуулан баталгаажуулах ба төгсөлт хариуцсан ажилтан материалыг 06 дугаар сарын 05-наас 07-ны өдрүүдэд СБХА-ны төгсөлт хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
- 4.16. Төгсөх оюутны дипломын мэдээллийг UNIMIS-ээс 06 дугаар сарын 07-ны 09:00 цагт татаж төгсөгчдөд олгох дээд боловсролын диплом, түүний хавсралтыг БШУЯ-наас баталсан “Дээд боловсролын диплом олгох журам”-ыг баримтлан төлөвлөсөн хугацаанд хэвлэн гаргана.
- 4.17. ШУТИС-ийн СБХА бүрэлдэхүүн, харьяа сургуулиудын төгсөлтийн салбар комиссын тогтоол, шийдвэрүүдийг үндэслэн нэр бүхий төгсөх оюутанд тодорхой хөтөлбөр/мэргэжлээр бакалавр, магистрын зэргийн диплом олгох ШУТИС-ийн захирлын тушаалыг төлөвлөн 06 дугаар сарын 15-ны өдөр баталгаажуулна.
- 4.18. ШУТИС-ийн СБХА, АТХА, ОХСҮА, СЧА болон төгсөлтийн нарийн бичиг хамтран 2022-2023 оны хичээлийн жилийн хаврын улирлын төгсөгчдөд диплом гардуулах ёслолын арга хэмжээг 06 сарын 15,16-ны өдрүүдэд зохион байгуулна.

ТАВ. МАРГААНТАЙ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ

- 5.1 Багш эсвэл суралцагч хичээлийн явцын үнэлгээний асуудлаар 5 сарын 25-ны дотор, улирлын шалгалтын дунгийн асуудлаар 5 сарын 31-ний дотор өргөдөл гаргаж болно.
- 5.2 Өргөдлийг заасан хугацаанд СЧА-ны даргад ирүүлэх ба дарга хичээл заасан багштай холбогдон суралцагчийн явцын үнэлгээ, улирлын шалгалтын материалыг дахин хянаж магадлана.
- 5.3 Хянан магадлагаа хийсний дараа засвар өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд СЧА-ны дарга ШУТИС-ийн СБХА-нд хандах ба тус албаны

мэргэжилтэн хичээл заасан багшид UNIMIS-д оруулсан дүнг засварлах эрх олгоно.

- 5.4 Маргаантай асуудлыг хичээл заасан багш хүлээн аваагүй тохиолдолд бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар ажлын хэсэг томилон гомдол гаргасан суралцагчийн шалгалтын материал, үнэлгээний арга зүй, хэрэглэгдэхүүн(бодлого, тестийн зөв хариу гэх мэт)-ийг хянан магадалж, зохих дүгнэлт, шийдвэр гаргана.